

2023 ОНЫ 10 ДУГААР САРЫН 05-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2023 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2023 ОНЫ 10 ДУГААР САРЫН 05-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААН



ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

2023 ОНЫ 10 ДУГААР САРЫН 05-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2023 оны 10 дугаар сарын 05-ны өдөр, Пүрэв гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	1-3
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	4-13

1. “Онцгой байдлын ерөнхий газарт гал унтраах тусгай зориулалтын машин нийлүүлэх төсөл”-ийг хэрэгжүүлэх Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газар хоорондын Санхүүгийн хэлэлцээрийн төсөл /Засгийн газар 2023.10.04-ний өдөр ирүүлсэн, зөвшилцөх/	4-10
2. “Онцгой байдлын ерөнхий газрын агаараас аврах ангид нэмэлт сургалт явуулах төсөл”-ийг хэрэгжүүлэх Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газар хоорондын Санхүүгийн хэлэлцээрийн төсөл /Засгийн газар 2023.10.04-ний өдөр ирүүлсэн, зөвшилцөх/	10-13

2023 ОНЫ 10 ДУГААР САРЫН 05-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы
Аюулгүй байдал, гадаад бодлогын болон Төсвийн байнгын хороодын
10 дугаар сарын 05-ны өдөр /Пүрэв гараг/-ийн хамтарсан
хуралдааны товч тэмдэглэл**

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дарга Б.Энх-Амгалан ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 33 гишүүнээс 17 гишүүн хүрэлцэн ирж, 51.5 хувийн ирцтэйгээр хуралдаан 14 цаг 03 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: С.Ганбаатар, Л.Мөнхбаатар, Д.Өнөрболор, Д.Цогтбаатар;

Чөлөөтэй: Г.Тэмүүлэн, П.Анужин, Х.Булгантуяа, Б.Чойжилсүрэн;

Эмнэлгийн чөлөөтэй: Ц.Сэргэлэн, Ж.Эрдэнэбат;

Тасалсан: Н.Алтанхуяг, Ц.Даваасүрэн, Б.Дэлгэрсайхан, Ш.Раднаасэд, Ч.Хүрэлбаатар.

Нэг. “Онцгой байдлын ерөнхий газарт гал унтраах тусгай зориулалтын машин нийлүүлэх төсөл”-ийг хэрэгжүүлэх Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газар хоорондын Санхүүгийн хэлэлцээрийн төсөл /Засгийн газар 2023.10.04-ний өдөр ирүүлсэн, зөвшилцөх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Онцгой байдлын ерөнхий газрын дарга Г.Ариунбуян, мөн газрын Бодлого төлөвлөлтийн газрын дарга Л.Өлзийбаяр, Гал түймэртэй тэмцэх газрын дарга Ц.Нямбаяр, Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга Б.Сүх-Очир, мөн яамны Санхүүгийн бодлогын газрын Өрийн удирдлагын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Санхүүгийн хөрөнгө удирдлагын хэлтсийн дарга С.Тулга нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ж.Чимгээ, референт Б.Гандиймаа, Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул, Үйлдвэржилтийн бодлогын байнгын хороо хариуцсан референт Б.Ууганцэцэг, Хяналт шалгалт, үнэлгээний газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Эрдэнэсамбуу нар байлцав.

Төслийн талаарх танилцуулгыг Сангийн сайд Б.Жавхлан, төслийн зөвшилцөх асуудлын талаар Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр нар танилцуулав.

Танилцуулга болон Байнгын хорооноос ирүүлсэн санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбат, Ц.Анандбазар, Б.Жавхлан нарын тавьсан асуултад Онцгой байдлын ерөнхий газрын дарга Г.Ариунбуян хариулж, тайлбар хийв.

Б.Энх-Амгалан: “Онцгой байдлын ерөнхий газарт гал унтраах тусгай зориулалтын машин нийлүүлэх төсөл”-ийг хэрэгжүүлэх Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газар хоорондын Санхүүгийн хэлэлцээрийн төслийг зөвшөөрч, гарын үсэг зурах эрхийг Засгийн газарт олгоё гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

2023 ОНЫ 10 ДУГААР САРЫН 05-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

Зөвшөөрсөн: 15
Татгалзсан: 3
Бүгд: 18
83.3 хувийн саналаар дэмжигдлээ.

“Онцгой байдлын ерөнхий газарт гал унтраах тусгай зориулалтын машин нийлүүлэх төсөл”-ийг хэрэгжүүлэх Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газар хоорондын Санхүүгийн хэлэлцээрийн төслийг хэлэлцсэн тухай Байнгын хороодын хуралдааны тэмдэглэл болон санал, дүгнэлтийг Засгийн газарт хүргүүлэхээр тогтов.

Уг асуудлыг 14 цаг 26 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр. “Онцгой байдлын ерөнхий газрын агаараас аврах ангид нэмэлт сургалт явуулах төсөл”-ийг хэрэгжүүлэх Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газар хоорондын Санхүүгийн хэлэлцээрийн төсөл /Засгийн газар 2023.10.04-ний өдөр ирүүлсэн, зөвшилцөх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Онцгой байдлын ерөнхий газрын дарга Г.Ариунбуян, мөн газрын Бодлого төлөвлөлтийн газрын дарга Л.Өлзийбаяр, Гал түймэртэй тэмцэх газрын дарга Ц.Нямбаяр, Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга Б.Сүх-Очир, мөн яамны Санхүүгийн бодлогын газрын Өрийн удирдлагын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Санхүүгийн хөрөнгө удирдлагын хэлтсийн дарга С.Тулга нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ж.Чимгээ, референт Б.Гандиймаа, Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул, Үйлдвэржилтийн бодлогын байнгын хороо хариуцсан референт Б.Ууганцэцэг, Хяналт шалгалт, үнэлгээний газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Эрдэнэсамбуу нар байлцав.

Төслийн зөвшилцөх асуудлын талаар Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр нар танилцуулав.

Байнгын хорооноос ирүүлсэн санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбат, Ц.Анандбазар, Б.Энх-Амгалан нарын тавьсан асуултад Онцгой байдлын ерөнхий газрын дарга Г.Ариунбуян хариулж, тайлбар хийв.

Б.Энх-Амгалан: “Онцгой байдлын ерөнхий газрын агаараас аврах ангид нэмэлт сургалт явуулах төсөл”-ийг хэрэгжүүлэх Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газар хоорондын Санхүүгийн хэлэлцээрийн төслийг зөвшөөрч, гарын үсэг зурах эрхийг Засгийн газарт олгоё гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 15
Татгалзсан: 2
Бүгд: 17
88.2 хувийн саналаар дэмжигдлээ.

2023 ОНЫ 10 ДУГААР САРЫН 05-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

“Онцгой байдлын ерөнхий газрын агаараас аврах ангид нэмэлт сургалт явуулах төсөл”-ийг хэрэгжүүлэх Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газар хоорондын Санхүүгийн хэлэлцээрийн төслийг хэлэлцсэн тухай Байнгын хороодын хуралдааны тэмдэглэл болон санал, дүгнэлтийг Засгийн газарт хүргүүлэхээр тогтов.

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 33 минут үргэлжилж, 33 гишүүнээс 18 гишүүн хүрэлцэн ирж, 54.5 хувийн ирцтэйгээр 14 цаг 36 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Б.ЭНХ-АМГАЛАН

ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Г.ТЭМҮҮЛЭН

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ ХӨТЛӨХ
АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

П.ОЮУНГЭРЭЛ

2023 ОНЫ 10 ДУГААР САРЫН 05-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2023 оны 10 дугаар сарын 05-ны өдөр,
Пүрэв гараг Төрийн ордон
“Жанжин Д.Сүхбаатар” танхим
14 цаг 03 минут.

**АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД
БОДЛОГЫН БОЛОН ТӨСВИЙН
БАЙНГЫН ХОРООДЫН 10 ДУГААР
САРЫН 05-НЫ ӨДӨР /ПҮРЭВ ГАРАГ/
ИЙН ХАМТАРСАН ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

Б.Энх-Амгалан: Эрхэм гишүүдийн
энэ өдрийн амар амгаланг айлтгая.

Аюулгүй байдал, гадаад бодлогын
байнгын хороо, Төсвийн байнгын хорооны
хамтарсан хуралдаанд гишүүдийн ирц
бүрдсэн тул 2023 оны 10 дугаар сарын 05-
ны өдрийн Байнгын хороодын хамтарсан
хуралдааныг нээснийг мэдэгдье.

Ажлын хэсгийн гишүүдийг
оруулаарай.

Аюулгүй байдал, гадаад бодлогын
байнгын хороо, Төсвийн байнгын хорооны
хамтарсан хуралдаанд оролцож байгаа
гишүүдийн ирц бүрдсэн тул Байнгын
хороодын хамтарсан хуралдаанаар
хэлэлцэх асуудлыг та бүхэнд
танилцуулъя.

Хэлэлцэх асуудал.

“Онцгой байдлын ерөнхий газарт
гал унтраах тусгай зориулалтын машин
нийлүүлэх төсөл”-ийг хэрэгжүүлэх
Монгол Улсын Засгийн газар, Бүгд
Найрамдах Франц Улсын Засгийн газар
хоорондын санхүүгийн хэлэлцээрийн
төсөл. Засгийн газар 2023 оны 10 сарын
04-ний өдөр ирүүлсэн, зөвшилцөх,

2. “Онцгой байдлын ерөнхий газрын
агаараас аврах ангид нэмэлт сургалт
явуулах төсөл”-ийг хэрэгжүүлэх Монгол
Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах

Франц Улсын Засгийн газар хоорондын
санхүүгийн хэлэлцээрийн төсөл. Засгийн
газар 2023 оны 10 сарын 04-ний өдөр
ирүүлсэн, зөвшилцөх. Ийм 2 асуудлыг
хэлэлцэнэ.

Хэлэлцэх асуудалтай
холбоотойгоор өөр саналтай гишүүн
байна уу? Алга байна. Хэлэлцэх
асуудалдаа оръё.

**“Онцгой байдлын ерөнхий газарт
гал унтраах тусгай зориулалтын
машин нийлүүлэх төсөл”-ийг
хэрэгжүүлэх Монгол Улсын Засгийн
газар, Бүгд Найрамдах Франц Улсын
Засгийн газар хоорондын санхүүгийн
хэлэлцээрийн төслийг хэлэлцье.**

Чуулганы хуралдааны дэгийн
хуралдааны дагуу хэлэлцэж байгаа
асуудалтай холбогдуулан хуралдаанд
оролцож байгаа албан тушаалтнуудыг
танилцуулъя.

1. Болдын Жавхлан Улсын Их
Хурлын гишүүн, Засгийн газрын гишүүн,
Сангийн сайд, 2. Ариунбуян Онцгой
байдлын ерөнхий газрын дарга, хошууч
генерал, Б.Сүх-Очир Сангийн яамны
Санхүүгийн бодлогын газрын дарга,
Л.Өлзийбаяр Онцгой байдлын ерөнхий
газрын Бодлого төлөвлөлтийн газрын
дарга, хурандаа, Ц.Нямбаяр Онцгой
байдлын ерөнхий газрын Гал түймэртэй
тэмцэх газрын дарга, хурандаа, Б.Мөнх-
Оргил Монгол Улсын Шадар сайдын ахлах
зөвлөх бөгөөд ажлын албаны дарга байна
уу, оруулаарай. С.Тулга Сангийн яамны
Санхүүгийн бодлогын газрын Өрийн
удирдлагын хэлтсийн даргын үүргийг түр
орлон гүйцэтгэгч, Санхүүгийн хөрөнгө
оруулалтын хэлтсийн дарга. Эдгээр хүний
бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг ирсэн
байна.

Төслийн талаарх танилцуулгыг
Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газрын
гишүүн, Сангийн сайд Болдын Жавхлан
танилцуулна. Жавхлан сайдын
микрофоныг өгье.

2023 ОНЫ 10 ДУГААР САРЫН 05-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

Б.Жавхлан: Эрхэм Байнгын хорооны дарга, Улсын Их Хурлын гишүүд ээ. Саяын Байнгын хорооны даргын танилцуулсан 2 гэрээний танилцуулга нь нэг юм байгаа юм шүү. Байнгын хорооны дарга аа, тийм. Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газраас 2019 онд авсан 58 сая еврогийн зээлийн хөрөнгөөр онцгой байдлын байгууллагад агаараас авах нэгж байгуулах нисдэг тэрэг, гал унтраах тусгай зориулалтын автомашин нийлүүлэх төслийг хэрэгжүүлж байна.

Төслийн хүрээнд одоогоор нийт 4 нисдэг тэрэг худалдан авч, нисдэг тэрэгний дэд бүтцийг байгуулж, нисгэгч, инженерүүдийг сургалтад хамруулсан бөгөөд 23 оны 9 дүгээр сарын байдлаар 85 удаагийн тусгай үүргийн нислэг үйлдэж, ослын улмаас бэртэж гэмтсэн, газраар тээвэрлэх боломжгүй нөхцөл байдал байсан 122 иргэний амь насыг аварч, анхан шатын тусламж үйлчилгээг шуурхай үзүүлэн дараагийн шатын эмнэлгийн байгууллагад цаг алдалгүй хүлээлгэн өгөгдсөн. Түүнчлэн тусгай тоноглол бүхий 42 гал унтраах автомашиныг нийслэл болон орон нутгийн Онцгой байдлын ерөнхий газрын харьяа Гал түймэр унтраах ангиудад хүлээлгэн өгч, онцгой байдлын байгууллагын албан хаагчдыг сургалтад хамруулан 2235 удаагийн дуудлагаар үүрэг гүйцэтгэн, 853 хүний амь нас аюулгүй байдлыг хангаж ажилласнаас гадна 216,8 тэрбум төгрөгийн үнэ бүхий эд хөрөнгийг эвдэж сүйтгэхээс сэргийлэх үүрэг гүйцэтгэсэн болно.

Монгол Улсад оруулсан дээрх хувь нэмэр, нийгмийн үр өгөөжийг өндрөөр үнэлж, Бүгд Найрамдах Франц Улсын Ерөнхийлөгч Эмманюэль Макроний Монгол Улсад 23 оны 5 дугаар сард хийсэн айлчлалын үеэр 2 улсын Ерөнхийлөгч нарын хамтарсан тунхаглал дээрх төслийг онцлон дурдаж, цаашид үргэлжлүүлж төслийн 2 дугаар үе шатыг эхлүүлэх нь зүйтэй гэж тогтсон юм.

Төслийн 2 дугаар үе шатын хүрээнд онцгой байдлын байгууллагын 12 нисгэгчийг чадавхжуулах, мэргэжлийн өндөр түвшинд бэлтгэх, аврах ажиллагааны мэргэжилтэн, аврагч, эмч, сувилагч нарын мэргэжлийн ур чадварыг сайжруулах, нисдэг тэрэгний засвар үйлчилгээ хийх, инженер, үндэсний инженерүүдийг бэлтгэх, холбогдох программ хангамж дэд бүтцүүдийг бэлэн болгох, гал түймэр хөөсөөр унтраах автомашин болон автомеханик шатны автомашин хөөс үүсгэгч бодис авч, аюулт үзэгдэл гал түймэр унтраах үйл ажиллагааг сайжруулах юм.

Монгол Улсын Ерөнхийлөгч Бүгд Найрамдах Франц Улсад 2023 оны 10 дугаар сард хийх Төрийн айлчлалын үеэр төслийн 2 дугаар үе шатыг хэрэгжүүлэх санхүүгийн хэлэлцээрт гарын үсэг зурахаар төлөвлөн ажиллаж байгаа бөгөөд энэхүү зээл нь жилийн 0,282 хувийн хүүтэй, 20 жилийн хугацаатай, 38 сая евротой тэнцэх хэмжээний нэн хөнгөлөлттэй зээл юм.

Дээрх төсөл нь Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 75.3-д заасан шаардлагыг хангаж байгаа бөгөөд Алсын хараа 2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 7.3.20, Монгол Улсын Засгийн газрын 2020-24 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.3.11-д туссанаас гадна, төсвийн төсөөлөлд тусгагдсан гадаад зээлийн хөрөнгийг авч хэрэг ашиглах тохиолдолд Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан Засгийн газрын өрийн тухай төсвийн тусгай шаардлагыг бүрэн хангаж байгаа болно.

Ийнхүү ийм төслийн 2 дугаар үе шат буюу сая Байнгын хорооны даргын танилцуулсан 2 үе шатыг хүрээнд хэрэгжүүлэх 1 дүгээрт, Агаараас аврах ангид нэмэлт сургалт явуулах төсөл, 2 дугаарх нь гал унтраах тусгай зориулалтын машин нийлүүлэх төслийн санхүүгийн хэлэлцээрүүдийг хэлэлцэн

2023 ОНЫ 10 ДУГААР САРЫН 05-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

дэмжиж өгнө үү. Анхаарал тавьсанд баярлалаа.

Б.Энх-Амгалан: Жавхлан сайдад баярлалаа. Төслийн талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Баагаагийн Баттөмөр танилцуулна. Баттөмөр гишүүний микрофоныг өгье.

Б.Баттөмөр: Байнгын хорооны дарга, гишүүд ээ, Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 10 дугаар сарын 04-ний өдөр “Онцгой байдлын ерөнхий газарт гал унтраах тусгай зориулалтын автомашин нийлүүлэх төсөл”-ийг хэрэгжүүлэх Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газар хоорондын санхүүгийн хэлэлцээрийн төслийг Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороотой зөвшилцөхөөр ирүүлсэн.

Эдийн засгийн байнгын хороо 2023 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн хуралдаанаараа Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 75¹.1 дүгээр зүйлийн 75¹.1.1-д заасныг баримтлан хэлэлцээрийн төслийг зөвшилцөх санал бас асуудлыг хэлэлцлээ.

Төсөл санаачлагчийн зүгээс уг санхүүгийн хэлэлцээрийн хүрээнд онцгой байдлын байгууллагад нэн шаардлагатай гал түймэр унтраах автомашин болон цаашид гал унтраах ангийг хүчин чадал өндөр шинэ үеийн тоног төхөөрөмжөөр хангахаар төлөвлөснийг дурдсан байна.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшин, Оюунчимэг, Ундрам нар зээлийн хэлэлцээрийн зөвшилцөхийг дэмжиж, төсөлд тусгагдсан техник тоног төхөөрөмжийг хүн амын төвлөрөл ихтэй сум, алслагдсан бүс нутагт хуваарилах боломжтой эсэх, төслийн хөрөнгөөр Онцгой байдлын ерөнхий газарт нисдэг тэрэг шинээр нэмж авах боломжийн талаар асуулт асууж, үг хэлсэн болно.

Онцгой байдлын ерөнхий газар гал унтраах тусгай зориулалтын машин нийлүүлэх төслийг хэрэгжүүлэх Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газар хоорондын санхүүгийн хэлэлцээрийн төслийг Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх нь зөвшилцөхийг дэмжиж, санал, дүгнэлтээ Төсвийн болон Аюулгүй байдлын байнгын хороонд хүргүүлэхээр шийдвэрлэлээ. Анхаарал тавьсанд баярлалаа.

Б.Энх-Амгалан: Баттөмөр гишүүнд баярлалаа.

Зөвшилцөхөөр ирүүлсэн төсөл болон танилцуулгатай холбогдуулан асуулт асуух гишүүд байвал нэрээ өгнө үү. Анандбазар гишүүнээр тасаллаа.

Монгол Улсын Их Хурлын хуралдааны дэгийн тухай хуулийн 13.1.2-т заасны дагуу асуулт асуух гишүүн хугацаа 4 минутаас илүүгүй, нэмэлт асуулт асуух хугацаа 1 минутаас илүүгүй байх бөгөөд хариулт тайлбар хангалтгүй гэж үзвэл 1 минутаас илүүгүй хугацаагаар нэмэлт асууж тайлбар авч болно. Хариулт 4 минутаас илүүгүй байна. Нэмэлт тайлбар өгөх хугацаа 2 хүртэл бөгөөд тус бүр 1 минутаас илүүгүй байна гэж заасныг сануулъя.

Ганбат гишүүний микрофоныг өгье. Ганбат гишүүн асуултаа асууя.

Д.Ганбат: Өнөөдрийн ярьж байгаа энэ онцгой байдлын газарт гал унтраах энэ сургалт явуулах Францын зээл тусламжаар явуулж байгаа. Үүнийг дэмжиж байна. Ер нь бол бид нар бас гуравдагч хөршийн бодлого, тэргүүний техник технологийг бол бас улс орондоо оруулж ирэх нь зөв. Тэр тусмаа энэ 23 он бас Монгол Улсын хувьд үнэхээр ач холбогдолтой он байлаа. Францын Ерөнхийлөгч Эмманюэль Макрон Монгол Улсад Монгол Улсын Ерөнхийлөгчийн урилгаар айлчилсан. Одоо удахгүй Монгол Улсын Ерөнхийлөгч Хүрэлсүх Франц

2023 ОНЫ 10 ДУГААР САРЫН 05-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

Улсад айлчлах гэж байна. Тэгээд Франц улсын техник технологи бол ер нь бас тэргүүний техник технологи гэж явдаг. Энэ талаар ингээд сургалт явуулаад ингээд явах нь зөв өө. Үүнийг авах нь зөв өө. Гэхдээ энэ Францын бас нэг хэдэн нисдэг тэрэг орж ирсэн үү ямар байгаа юм? Түүн дээр сургалт судалгаа явуулаад нэг нь аваар осолд орсон сураг байсан. Тэр ямар учиртай, юу болоод яачхав, одоо ямар шатдаа яваа, зассан уу, залруулсан уу нэг ийм юм байна.

Нөгөө талаар бас юу байна. Уулын бугыг хараад унасан бухаа мартаж болохгүй гэж. Бид нар олон жил бас энэ хойд хөрштэйгөө ОХУ ЗХУ гэж байхаас эхэлж нөхөрлөж, хамтарч явсан. Энэ дээр бол олон техник технологиуд байгаа байх гэж бодож байна. Тэгээд ингээд олон зүйлийг холиод яваад байх нь зөв үү, буруу юу.

Сүүлийн үед яах вэ, манай хойд хөрш маань бас дайн дажны байдалтай, техник технологийн хувьд баталгаат түвшин нь ямар байна? Нөгөө нэг манай нөгөө Миг нисдэг тэргүүд ямар байна аа? Нэг удаа осолд орж байсан санагдаж байна. Нэлээн хэдэн жилийн өмнө. Онцгой байдлын албан хаагчид бас бие бүрэлдэхүүнээсээ хэд хэдэн хүнийг алдсан ийм эмгэнэлт явдал болж байсан. Түүн дээрээ анхаарч, энэ техник тоног төхөөрөмжөө засвар үйлчилгээ хийж байгаа юу?

Сүүлийн үед гамшигийн нөхцөл байдал өдөр ирэх тусам, жил ирэх тусам энэ дэлхийн дулаарал, нөгөө Нэгдсэн үндэстний ЕНБД-ын хэлдгээр бол бараг шатаж байна шүү дээ, дэлхий. Ган гачиг ихтэй. Улаанбаатар хот маань өөрөө энд тэнд очиж бас гал унтраах, энэ тэр юманд бол нэлээн хэцүү байрлалтай гэж ойлгоод байгаа. Түгжрэлтэй, хот төлөвлөлт нь 21 дүгээр зууны өнөөгийн түвшинд бол хүрэх шаардлага хангахгүй ийм байдалд орчихсон байгаа. Энэ нөхцөлд бол бас тэр нисдэг тэрэг бол их ач холбогдолтой гэж байгаа, ойлгож

байна. Түүнийг тэр гал унтраах үйлс, аврах энэ юманд ашиглаж барих Улаанбаатар хотод боломж нь хэр байгаа вэ. Үүнийг анхаарч үзэж судалж бас тэр сургалт судалгаандаа хамруулж байгаа юу гэсэн ийм хэдэн асуулт байна.

Ер нь онцгой байдлын газрынхныг сүүлийн үед би бол сайн ажиллаад байгаа гэж бодож байгаа. Тэр боломжоороо тэр Хөвсгөл далайд очиж тэр Хөвсгөл далайд унасан машин, техник энэ бүх юмнуудыг олон жилийн өмнө болохгүй, бүтэхгүй байсан юмыг гаргаж барьж ажиллаж байна гэж ойлгож байна. Олон ч хүн аварч ажиллаж байна. Тэгээд нөхцөл байдал ямар байх вэ?

Цаашидаа бас хүндэрч магадгүй байдалтай байна. Энэ бүхэнд та бүхэн бэлэн байгаа юу? Энэ орж ирж байгаа техник, тоног төхөөрөмж, энэ сургалтууд та бүхэнд үнэхээр үр нөлөө ... /минут дуусав/

Б.Энх-Амгалан: Асуудлыг хуралдааны дэгийн тухай хуулийн дагуу хэлэлцэж байгаа. Энэ удаагийн хэлэлцэж байгаа асуудал Онцгой байдлын ерөнхий газарт гал унтраах зориулалттай тусгай зориулалтын автомашин нийлүүлэх төслийг хэлэлцэж байгаа учраас нисдэг тэрэгтэй холбоотой асуудлыг нь 2 дугаар асуудал дээр хариулаарай.

Одоо эхнийх нь бусад асуудал дээр нь хариулт өгөөд явчихъя. Хэн хариулах вэ? 5 номер. Онцгой байдлын ерөнхий газрын дарга хариулъя. Ариунбуян генерал.

Г.Ариунбуян: Байнгын хорооны дарга, гишүүдийнхээ өдрийн амгаланг айлтгая. Ганбат гишүүний асуултад хариулъя. Гал унтраах тусгай зориулалтын автомашин I дүгээр шатны төслийн хүрээнд 42 ширхэг нийлүүлэгдсэн. Ер нь бол онцгой байдлын байгууллагад ОХУ, Бүгд Найрамдах Беларусь улс, Польш, Австри, Франц улс, Япон гээд олон улс орнуудын гал унтраах

2023 ОНЫ 10 ДУГААР САРЫН 05-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

тусгай зориулалтын автомашинууд нийлүүлэгддэг. Тэгэхдээ эдгээр машинууд нь манай орны байгаль цаг уурын нөхцөл байдал, хүн амын төвлөрөл, гэр хорооллын нөхцөл байдалтай холбогдуулаад бид нар техникийн шаардлага дээрээ энэ асуудлыг тусгайлан зааж өгч нийлүүлж байгаа.

Гол нь стандартын хувьд бол бүгд нэг, ерөөсөө. Бүх улс орнуудад үйлдвэрлэж байгаа автомашинууд нэг стандартаар үйлдвэрлэгддэг. Ер нь бид нар евро стандартыг илүү чухалчилж байгаа. Дэлхийн улс орнуудад бол евро стандарт бол илүү их найдвартай, техникийн хувьд бол эвдрэл гэмтэл багатай. Дээр нь ложистик тээврийн хувьд ч гэсэн боломжтой гэдэг агуулгаар нь бид бүхэн евро стандартыг нийлүүлэхэд бол илүү анхаарал хандуулж байна.

Цаашид техник тоног төхөөрөмжийн хувьд бол илүү сайжруулах шаардлага бий. Өнөөдөр бол гал унтраах аврах ангиудад ашиглагдаж байгаа машин механизм техникийн бол нийт хангамжийг авч үзэх юм бол улсын хэмжээнд 59 хувьтай. Улаанбаатар хотод бол 50, 55 орчим хувьтай байгаа юм. Тэгэхээр эдгээр машинууд нийлүүлэгдсэнээр бид нар бол ядаж машин, тоног төхөөрөмжийн хангамж бол тодорхой тоогоор өсөхийн зэрэгцээ иргэдийн аюулгүй байдлыг хангах, ялангуяа хот суурин газар, барилга байгууламж, уул уурхай, худалдаа үйлчилгээний салбаруудад яаралтай гал унтраах үйл ажиллагааг зохион байгуулахад ихээхэн дэмжлэг үзүүлнэ гэж үзэж байна.

Б.Энх-Амгалан: Анандбазар гишүүн асуултаа асууя.

Ц.Анандбазар: Баярлалаа. Онцгой байдлын шаардлагатай нөхцөлд хэрэглэгдэх ийм нисдэг тэрэг, орчин үеийн тоног төхөөрөмжөөр хангагдаж байгаа цаг үеэ олсон зөв шийд ээ, дэмжиж байна.

Тэгэхдээ энэ онгоцны нөөц хийж, баг бүрэлдэхүүн нисгэгчээ бэлдэхээс гадна дэд бүтцээ бэлдэх ёстой ийм чухал ажил байгаа. Өөрөөр хэлбэл энэ онгоцнуудыг хамгийн хурдан байдлаар ашиглахад Улаанбаатар хотод буух талбай, энд ашиглагдах дэд бүтцийн бэлтгэл ажил хамт явж байх ёстой. Тэгээд энэ улсын төсөв одоо хэлэлцэж байгаа үед ялангуяа үүнийг ярих ёстой байх гэж бодож байна. Яагаад гэвэл нисдэг тэрэгтэй байлаа гээд хол буух юм бол энэ нисдэг тэрэгний ач холбогдол алга болно. Ялангуяа шинэ онгоцны буудал дээр буух юм бол үр дүн ерөөсөө гарахгүй ээ.

Дээр нь нисдэг тэрэг өөрөө их зардалтай, алсын зайтай нислэг үйлдэхэд бас шаардлага хангадаггүй. Энэ авч байгаа нисдэг тэрэгнүүд бүгд Говь-Алтай дээр жишээ нь баруун аймаг явахад бууж байж, сумлаж байж наашаа ирнэ. Тэгээд яаралтай экстрены үйлчилгээ явуулахад жижиг оврын онгоц буюу зайлиггүй хэрэгцээтэй ийм олон улсын үйлчилгээ байдаг. Хувийн компаниуд олон онгоцтой болсон. Тэгээд ганцхан чиглэлийн буюу тусгай зориулалтын нисдэг тэрэгнээс гадна энэ жижиг оврын онгоцнуудыг ашиглах юм бол яаралтай тусламжийн үйлчилгээ, энэ онцгой байдлын үед хэрэглэгдэх үйл ажиллагаа улам сайн болох юм.

Тийм учраас онцгой байдлын даргаас нэг зүйл асуумаар байна. Энэ нисдэг тэрэг, жижиг бага оврын онгоцнуудын Улаанбаатар хотын эргэн тойронд буух зурвас, тэдгээрт үйлчилгээ хийх талбай яаж бэлдэж байгаа вэ? Шинэ онгоцны буудлаас наашаа ирэх юм бол энэ нисдэг тэргээр авчирсны хэрэг байхгүй. Яармаг дээр бөглөрөөд дуусна. Бэлдсэн зарим нэг талбай байдаг юм билээ. Тэр бол бас ашиглалтын шаардлага хангахгүй байгаа.

Тийм учраас шинээр буух, суух зурвас Улаанбаатар хотын эргэн тойронд хийх ёстой. Ялангуяа эмнэлэг үйлчилгээний газартай ойрхон. Үүнийг

2023 ОНЫ 10 ДУГААР САРЫН 05-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

хамт шийдэж байж, энэ үйлчилгээ чинь цогц болно оо. Хэчнээн сайхан үнэтэй тэрэг техник авчхаад, дэд бүтцийг нь бэлдэхгүй бол ашиглалт муутай болно. Тийм болохоор үүнийг хамт шийдэж энэ төсөв дээр цуг оруулж ирж энэ тусламжийн үр дүнг эдийн засгийн талаасаа ашигтай болгох ёстой юм. Энэ тал дээр бодож байгаа юм юу байна вэ? Ялангуяа жижиг оврын онгоцны тухайд ямар бодлого барьж байна? Онгоц бол ер нь нисдэг тэрэгнээс ашиглалтын зардал 2 дахин хямд бөгөөд хурдан, шуурхай, багтаамж өндөр, ийм ач холбогдолтой байдаг. Алсгал сайтай.

Дээр нь заавал улсын хөрөнгөөр өндөр үнэтэй вертолёт авна гэдэг бол төсөв дээр маш том дарамт ирнэ. Цаашидаа вертолёт гэж бодохоос илүү хувийн хэвшилд түшиглэсэн хөнгөн онгоцны үйлчилгээг нэвтрүүлэх ёстой юм. Тэгээд энэ зээл гэхээр л бид баярлаад гүйгээд авчихдаг. Үүний ашиглалтын зардал бол их өндөр байгаа. Тийм болохоор үүнийг давхар бодох ёстой юм байгаа юм. Тэгээд энэ жижиг онгоцны үйлчилгээ, дэд бүтэц энэ онгоц ирээд үйлчилгээнд ороход үүнтэй холбоотой бусад үйлчилгээний газрууд нь хэр бэлэн байна вэ, тодорхой саналууд юу байна вэ? Буух зурвас, суух буудлын тоо хэд байна вэ. Цаашидаа ямар төлөвлөгөө хийж байна гэдгийг тодруулж асуумаар байна.

Б.Энх-Амгалан: Гишүүд ээ, энэ Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн дагуу бид нарын хэлэлцэж байгаа асуудал бол Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газар хоорондын санхүүгийн хэлэлцээрийн эхний төсөл буюу Онцгой байдлын ерөнхий газарт гал унтраах тусгай зориулалтын автомашин нийлүүлэх төслийн тухай хэлэлцэж байгаа учраас 2 дахь асуудал дээр Онцгой байдлын ерөнхий газрын дарга хариулт өгөөд явчхаарай.

Эхний асуудал хэлэлцэж байгаа учраас эхний асуудалтай холбоотой

хариултуудыг өгье. Нэмээд Жавхлан гишүүн асуулт асууя.

Б.Жавхлан: Баярлалаа. Зүгээр гэрээтэй холбоогүй, зүгээр. Тэгэхдээ онцгой байдалтай холбоотой нэг юм хэлэх гэсэн юм. Ариунбуян генерал цаашидаа зүгээр анхаараарай. Юу вэ гэхээр яах вэ төсөл хэрэгжих эхний үе шатны хугацаанд 122 иргэнийхээ амь насыг аварч ингэсэн гэдэг бол маш сайн үр дүн. Ганц энэ үзүүлэлтээр нь л энэ төсөл ямар оновчтой сайн төсөл болсон бэ гэдэг нь харагдаж байгаа юм.

Зүгээр, цаашидаа нэг анхаарах зүйл байна. Манайх ингээд үндэсний их сайн нисгэгч нарыг энэ төслөөр ингээд бэлтгээд авч байгаа юм. Цаашидаа энэ хэдийгээ яг онцгой байдалтай төрдөө тогтвортой зүтгэх, тогтвортой ажиллах энэ нөхцөл боломжийг нь хэдүүлээ хангаж өгөх ёстой. Тэгэхгүй бол ингээд нисгэгч нар бэлдээд, тэгээд хувийн авиа компаниуд руу алдчих ийм нэг дамжлага бааз болчих эрсдэлтэй байгаа шүү.

Тийм учраас үүнийг маш сайн бодолцож, Шадар сайдтайгаа маш сайн ярилцаад, энэ төсөлтэйгөө цуг нэг тийм юм бодохгүй бол маш сайн нисгэгч нар бэлтгэнэ. Энэ нисгэгч нар чинь дараагийнхаа шавь нарыг бэлтгээд ингээд яг төрийн мэдлийн ийм тасралтгүй, маш том тэнд ийм бааз үүсэх ёстой, урт хугацаандаа, тийм ээ. Тэгэхгүй ингээд нэг зурвасхан хэдэн сайн нисгэгч бэлдээд тэрийгээ тэгээд алдчих вий. Нэг ийм юман дээр л бас санаа зовж эхэлж байгаа шүү. Тийм. Өөр юмгүй.

Б.Энх-Амгалан: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Энэ гал унтраах тусгай зориулалтын автомашин нийлүүлэх төсөл бол автомашин тоног төхөөрөмжийн хүчин чадлыг сайжруулах, газрын тосны бүтээгдэхүүн тэр дундаа газрын тос хадгалах агуулах

2023 ОНЫ 10 ДУГААР САРЫН 05-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

сав, томоохон талбайтай ШТС-ууд, томоохон хэмжээний худалдааны төвүүд, өндөр барилгуудад гарч байгаа энэ гал түймрүүдийг унтраах, аюулын голомтод түргэн шуурхай ажиллах ийм тоног төхөөрөмжүүд учраас манайхан энэ дээр нэлээн ач холбогдол өгч байна гэж ингэж ойлгож байна.

Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

2 дахь нь гишүүд зөвшилцөхөөр ирүүлсэн төсөл болон танилцуулгатай холбогдуулан үг хэлэх гишүүд байвал нэрээ өгнө үү. Алга байна. 2 дахь асуудалдаа оръё.

Уучлаарай. хэлэлцэж байгаатай холбоо асуудалтай холбогдуулан санал хураалт явуулж эхэлье.

“Онцгой байдлын ерөнхий газарт гал унтраах тусгай зориулалтын машин нийлүүлэх төсөл”-ийг хэрэгжүүлэх Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газар хоорондын санхүүгийн хэлэлцээрийн төслийг зөвшөөрч, гарын үсэг зурах эрхийг Засгийн газарт олгоё гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт, гишүүд ээ.

Санал хураалтад 18 гишүүн оролцож, 15 гишүүн дэмжиж, 83,3 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

Уг асуудлыг хэлэлцсэн тухай Төсвийн болон Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны хамтарсан хуралдааныг тэмдэглэл болон санал, дүгнэлтийг Засгийн газарт хүргүүлнэ.

Дараагийн асуудалдаа оръё.

“Онцгой байдлын ерөнхий газраас агаарын аврах ангид нэмэлт сургалт явуулах төсөл”-ийг хэрэгжүүлэх Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газар хоорондын

санхүүгийн хэлэлцээрийн төслийг хэлэлцье.

Төслийн танилцуулгыг хамтад нь Засгийн газрын гишүүн хийчихсэн. Тийм ээ. Засгийн газрын гишүүн, Сангийн сайд Жавхлан хийчихсэн.

Хэлэлцээрийн төслийн талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Баагаагийн Баттөмөр танилцуулна. Баттөмөр гишүүний микрофоныг өгье.

Б.Баттөмөр: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ, Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 10 сарын 04-ний өдөр “Онцгой байдлын ерөнхий газраас аврах ангид нэмэлт сургалт явуулах төсөл”-ийг хэрэгжүүлэх Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газар хоорондын санхүүгийн хэлэлцээрийн төслийг Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороотой зөвшилцөхөөр ирүүлсэн.

Эдийн засгийн байнгын хороо 2023 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн хуралдаанаараа Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 75¹.1 дүгээр зүйлийн 75¹.1.1-д заасныг баримтлан дээрх хэлэлцээрийн төслийг зөвшилцөх асуудлыг хэлэлцлээ.

Төсөл санаачлагчийн зүгээс агаарын хөлгийн 1 дүгээр шатын сургалтад хамрагдаж гэрчилгээ авсан инженер техникийн бүрэлдэхүүн, албан хаагчдын 2 дугаар шатны сургалтад хамруулах, нисдэг тэрэгний хөдөлгөөнийг задалж угсрах, техникийн үйлчилгээ, засварыг бие даан гүйцэтгэх чадвар эзэмшүүлэх, сургах, сургагч инженер, ажилтнуудыг Монгол Улсад ажиллуулах, нисэх тэрэгний сэлбэг хэрэгсэл нийлүүлэх, засвар үйлчилгээ хийх зайлигүй шаардлага байгааг дурдаад тус санхүүгийн хэлэлцээрийн хүрээнд эдгээр асуудлыг шийдвэрлэхээр тусгасан байна.

2023 ОНЫ 10 ДУГААР САРЫН 05-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

Байнгын хорооны хуралдаанаас төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, санал илэрхийлээгүй болно.

“Онцгой байдлын ерөнхий газраас агаараас аврах ангид нэмэлт сургалт явуулах төсөл”-ийг хэрэгжүүлэх Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газар хоорондын санхүүгийн хэлэлцээрийн төслийг Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх зөвшилцөхийг дэмжиж, санал, дүгнэлтээ Төсвийн болон Аюулгүй байдлын байнгын хороонд хүргүүлэхээр шийдвэрлэлээ. Анхаарал тавьсанд баярлалаа.

Б.Энх-Амгалан: Хэлэлцээрийн төслийн талаар ирүүлсэн төсөл болон танилцуулгатай холбогдуулан нэмж асуулт асуух гишүүн байна уу. Алга байна.

Ганбат гишүүний асуултад хариулъя. Ганбат гишүүн энэ нисдэг тэргүүд чинь шинэ юм уу, хуучин юм уу, нэг аваар осолд орсон ийм тохиолдол энэ тэр байна уу, үгүй юү? Зассан уу, засаагүй юу гэж юм тодруулсан. Түүн дээр нь Онцгой байдлын ерөнхий газрын дарга, хошууч генерал Ариунбуян хариулъя. 5 дугаар микрофон.

Г.Ариунбуян: Ганбат гишүүн болон Анандбазар гишүүний асуултад хариулъя. Франц Улсад үйлдвэрлэсэн энэ нисдэг тэрэг бол тухайн Франц Улсын иргэний аюулгүй байдлын салбарт 1950 оноос хойш ашиглагдаж байгаа. Ер нь бол олон улсын дэлхийн 30 гаруй улс орны онцгой байдал, эргийн хамгаалалт, хил хамгаалах, зэвсэгт хүчин, эрүүл мэндийн байгууллагад энэ Евро кофтер загварын нисдэг тэргийг ашиглаж байна.

Тэр унасан нисдэг тэрэгний хувьд бол энэ бол сургалтын зориулалттай жижиж оврын 2 хүний суудалтай, Кабри маркийн нисдэг тэрэг. Энэ нисдэг тэрэг дээр манай анхлан суралцаж байгаа сонсогч нисгэгч маань багшгүйгээр

дадлагын нислэг анх удаа хийж байх үедээ осолдсон байгаа юм. Энэ үеэр бол тухайн нисгэгчийн хувьд ямар нэгэн гэмтэж бэртсэн асуудал үүсээгүй. Энэ жижиж оврын нисдэг тэрэг маань давхар даатгалтай учраас ижил техникийн үзүүлэлттэй нисдэг тэргийг тухайн даатгалын компаниас энэ 11 дүгээр сард багтааж нийлүүлэхээр ажиллаж байна.

Ер нь цаашидаа энэ нисгэгч нарыг сургаж бэлтгэх асуудал бол үргэлжилнэ. Одоогоор манай нисгэгчид маань 100 цагийн лицензтэй буюу нисэх гэрчилгээтэй, нислэгийн анхан шатын сургалтад хамрагдсан. Цаашидаа Монгол Улсад мөрдөж байгаа улсын нислэгийн дүрмээр 500-аас доошгүй цагийн нислэгтэй байх ийм ур чадвартай болох сургалт бол 2 дахь шатын төслийн хүрээнд хэрэгжинэ.

Ер нь энэ алслалтын зай мөн техникийн энэ боломжоос шалтгаалаад энэ нисдэг тэрэгний үйлчилгээг тэгээд иргэдэд ойртуулах хүрээнд ер нь бүсчилсэн хэлбэрээр нэмэгдүүлэх, нисдэг тэрэгний тоог нэмэгдүүлэх, нисдэг тэрэгний инженер, техникийн ажилтан, нисгэгчдээ үе шаттай сургаж бэлтгэх асуудал бол чухал юм гэдэг нь бол цаашидаа бодлогын хүрээнд авч явах ёстой гэж ингэж бодож байна.

Анандбазар гишүүн дэд бүтцийн асуудлыг бол хөндөж ярьсан. Энэ бол их чухал асуудал. Үнэхээр өнөөдөр бол манай энэ агаараас эрэн хайх, аврах ажиллагаанд ашиглагдаж байгаа иж бүрэн тоноглогдсон нисдэг тэргийг бид бүхэн яаралтай тусламжийн үйлчилгээний зориулалттайгаар алслагдсан бүс нутагт осолдсон иргэдийг агаараас тээвэрлэх болон газраар тээвэрлэх боломжгүй нөхцөлд тээвэрлэж ирж байгаа.

Улаанбаатар хотод үүнийг буух хөөх зурвас бол Чингис хаан олон улсын буудал. Дээр нь Буянт-Ухаа нисэх онгоцны буудал дээр бол ашиглаж байна.

2023 ОНЫ 10 ДУГААР САРЫН 05-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

Сая үерийн үеэр бид энэ Үндэсний цэцэрлэгт хүрээлэн болон наад талын хүүхдийн паркт нисдэг тэргийг бол ашигласан. Тэгэхдээ нисдэг тэрэгний хувьд ямар нэгэн хөөх, буурах, хөөрөх, буух зурвас бас шаарддаггүйгээр онцлог. Ямар ч тохиолдолд үүрэг гүйцэтгэх боломжтой.

Цаашидаа төр, хувийн хэвилийн түншлэлийн хүрээнд энэ яаралтай тусламжийн үйлчилгээнд жижиг оврын онгоцыг бол зайлшгүй ашиглах, хамтарч ажиллах ийм хэрэгцээ шаардлага бол бий. Тэгээд энэ үндэснээс бид бүхэн бол Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд шинээр хөөх, хөөрөх, буух зурвасыг бол урьдчилсан байдлаар нислэгийн тодорхой нисгэгч, инженер техникийн ажилтнууддаа судалгаа хийж үзсэн. Тэнд дунджаар 1200 метрийн урттай хөөргөх зурвасыг бол үүсгэх ийм боломжтой. Байгалийн болон зохиомол саадууд бол байхгүй юм байна гэдэг ийм асуудал яригдаж байна. Энэ асуудлыг ИНЕГ мэргэжлийн байгууллагатай хамтарсан ажлын хэсэг дүгнэж, дүгнэлт гарсны дараа хэрэгжүүлэх боломжтой гэж үзэж байна.

Б.Энх-Амгалан: Нэг зүйл генералаас тодруулаадахъя. Саяын юун дээр хариулт дээр гарлаа. Энэ нөгөө хэлэлцээр чинь болохоор Онцгой байдлын ерөнхий газраас агаараас авран хамгаалах нэмэлт сургалт явуулах төсөл байгаа. Энэ төслийн задаргаа дээр засвар үйлчилгээ гээд нисдэг тэрэгний тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ гээд 5,1, сургалт дээрээ 13 сая доллар байна л даа. Тэгэхээр энэ маань саяын ярьчихсан багшгүйгээр ниссэн нөхрийн юмыг засах гэж байна уу эсвэл сургалтдаа зориулагдсан зардал уу. Түүнийг та нэг тодотгоодхооч. 5 номерын микрофон.

Г.Ариунбуян: 3 жилийн хугацаанд нийт 2700 цагийн нислэгийн даалгаврыг гүйцэтгэхээр төлөвлөж байгаа юм. Нийт 8 нисгэгч, туршилагатай 4 нисгэгч нийт 12 нисгэгч, 12 инженер, техникийн

ажилтнуудыг энэ хугацаанд бэлдэнэ. Мөн засвар, үйлчилгээ өөрөөр хэлэх юм бол хатуу цагтай 80, 50, 100, 500 гэдэг ч юм уу нисдэг тэрэгний их биед засвар үйлчилгээ хийх, хөдөлгүүрийг засварч оношлох энэ засвар үйлчилгээний зардал сэлбэг хэрэгслийн зардлууд бол энэ зардлын ангилалд бүгд багтсан байгаа. Тэгэхээр иж бүрэн гэсэн ойлгож болно.

Сургалтын нислэгтэй холбоотой асуудал нь бол даатгалынхаа журмаар зохицуулагдаад явчихна.

Б.Энх-Амгалан: Баярлалаа.

Зөвшилцөхөөр ирүүлсэн төсөлтэй холбогдуулж гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Зөвшилцөхөөр ирүүлсэн төсөл болон танилцуулгатай холбуулан үг хэлэх гишүүд байна уу. Алга байна.

Зөвшилцөхөөр ирүүлсэн төсөл болон танилцуулгатай холбуулж санал хураалт явуулъя.

“Онцгой байдлын ерөнхий газрын агаараас авран хамгаалах ангид нэмэлт сургалт явуулах төсөл”-ийг хэрэгжүүлэх Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газар хоорондын санхүүгийн хэлэлцээрийн төслийг зөвшөөрч, гарын үсэг зурах эрхийг Засгийн газарт олгоё гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт гишүүд ээ.

Санал хураалтад 17 гишүүн оролцож, 15 гишүүн дэмжиж, 88,2 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

Уг асуудлыг хэлэлцсэн тухай Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо, Төсвийн байнгын хорооны хамтарсан хуралдааны тэмдэглэл болон санал, дүгнэлтийг Засгийн газарт хүргүүлнэ.

2023 ОНЫ 10 ДУГААР САРЫН 05-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо, Төсвийн байнгын хорооны хамтарсан хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдааныг хаасныг мэдэгдье.

Хуралдаанд идэвхтэй оролцсон гишүүдэд болон ажлын хэсгийнхэнд баярлалаа.

Хуралдаан хаагдлаа.

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ*

П.ОЮУНГЭРЭЛ